

УКРАИНЫ ДАЙН БА КАЗАХСТАНЫ ГАДААД, ДОТООД ОРЧИН

Гагаагийн Алтанхишиг*

Abstract: *The war in Ukraine has accelerated the emergence of a new “Great Game” in Central Asia. Positioned within a unique geopolitical environment between major powers, Kazakhstan is seeking to navigate mounting geopolitical pressures while safeguarding its national interests. Although the war in Ukraine brings a range of political, social, and economic challenges for Kazakhstan, it also generates new opportunities. Through its multi-vector foreign policy, Kazakhstan aims to strengthen its position on the international stage, while domestically striving to enhance its resources and overall state capacity.*

Keywords: *Ukraine war, Kazakhstan*

Оршил

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин 2022 оны 2-р сарын 24-нд Украины эсрэг “цэргийн тусгай ажиллагаа” явуулах шийдвэр гаргаснаа зарласан (Kremlin, 2022). Энэхүү үйлдэл нь олон улсын эрх зүйн хувьд аль ч өнцгөөс тайлбарлаж болох маргаантай асуудал боловч, олон улсын харилцааны тогтсон дэг журмыг савлуулсан геополитикийн хямрал болсон гэдэг нь маргашгүй үнэн. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд энэхүү хямрал нь зөвхөн хоёр улсын хоорондын аль эсвэл бүс нутгийн хэмжээний асуудал биш, дэлхий дахиныг хамарсан үзэл суртал, ашиг сонирхлын дайн болж даамжрав.

Европ тивд өрнөж байгаа энэхүү дайн улс хоорондын харилцааны тогтсон хэм хэмжээ эрс өөрчлөгдөхөд нөлөөлсөн ба дэлхийн улс орнууд тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хангах стратегия эргэн харж, үндэсний ашиг сонирхлоо хамгаалах оновчтой бодлого боловсруулахад ихээхэн анхаарах болов. Геополитикийн сэргөлдөөн нэмэгдэх хэрээр их гүрнүүдийн өрсөлдөөн ОХУ-ын “амин ашиг сонирхлын бүсэд” тооцогддог Төв Азийн орнууд руу чиглэж байна. Үүнийг олон улсын харилцааны систем дэх АНУ-ын үнэмлэхүй жанжлал өндөрлөж, БНХАУ, ОХУ, ЕХ тэргүүтэй хүчний төвүүд дэлхий даяар өөрсдийн нөлөөний бүсээ тэлэхээр оролдож байна хэмээн үзэж болно. Системийн шилжилтийн энэхүү онцгой цаг үед Казахстан Улс хэрхэн хүчний тэнцвэрийг хадгалахыг оролдож буйг харуулахыг зорив.

Нэг. Казахстан олон ашиг сонирхлын уулзвар цэг болов

Украины дайн эхэлсэн нь Казахстан Улсад боломж ба сорилтын аль алиныг авчирсан. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд тус улсын эрх баригчид гадаад орчинд үүссэн цоо шинэ нөхцөл байдлыг өөрийн улсын эрх ашигт нийцүүлэн залуурдаж, сорилтыг шийдвэрлэж, боломжийг ашиглахаар эрмэлзэж байна. ОХУ-аас гадна АНУ, БНХАУ, ЕХ, Турк, БНСУ болон Арабын орнууд зэрэг тоглогчид Казахстантай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх замаар нөлөөгөө тэлэхийг оролдож байгаа бол нөгөө талд Казахстан тэдгээр тоглогчидтой эн тэнцүү харилцаж, өөрт шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах, технологи эзэмших замаар эдийн засгаа хөгжүүлэх, аюулгүй байдлаа бэхжүүлэхийг зорьж байна. Ингэхдээ хоорондоо зөрчилтэй байгаа ОХУ болон Өрнийн орнуудтай харилцахдаа улаан шугамыг давахгүй байхад ихээхэн анхаарал хандуулж байна.

Их гүрнүүдийн зүгээс Казахстаныг өөрийн талд татах, нөлөөний бүсдээ оруулах хэрэгцээ шаардлагыг олон янзаар тайлбарлаж болох ч стратегийн түвшинд дараах нийтлэг гурван асуудал анхаарал татдаг. Үүнд:

* МУИС-ийн УТСОУХНУС-ийн төгсөгч

Email: 20Altankhishig@gmail.com ORCID: 0009-0007-6323-4356

1. Газрын ховор элемент, чухал ашигт малтмал болон бусад стратегийн ач холбогдол бүхий байгалийн түүхий эд, ашигт малтмалын орд газруудыг эзэмших;
2. Өрнө-Дорныг хуурай газраар холбосон тээврийн коридорт хяналтаа тогтоох;
3. Олон улсын тавцанд Казахстан тэргүүтэй Төв Азийн орнуудын дэмжлэгийг авах.

Дээрх нийтлэг ашиг сонирхлоос гадна их гүрэн бүрд Казахстаныг өөрийн талд татах өвөрмөц стратегийн ашиг сонирхол бий. Тухайлбал, ОХУ-ын хувьд Хаант Оросын үеэс баримталж ирсэн “*зүрхэн газарт*” нөлөөгөө хадгалах бодлогыг үргэлжлүүлэхийг оролдож байгаа бол шинээр хүчирхэгжсэн БНХАУ-ын хил залгаа улс орон, бүс нутгуудад нөлөөгөө тэлэх бодлогод Казахстан багтсан. Харин сүүлийн үед Украины дайны нөхцөл байдлаас шалтгаалан хуваагдмал байр суурьтай болоод байгаа АНУ болон ЕХ зэрэг Өрнийн тоглогчдын хувьд Казахстанд нөлөөгөө тогтоох замаар ОХУ, Хятадын дундын бүсэд өөрийн ашиг сонирхлыг бий болгох, хүчний тэнцвэр тогтоохыг зорьж байгаа юм.

Ийнхүү Казахстан олон ашиг сонирхлын уулзвар цэг болж байгаа нь судлаачдын Төв Азийн бүс нутагт “*шинэ их тоглоом*” эхэлсэн хэмээх тодорхойлолтыг нотолж буй нэгэн үзэгдэл юм. Чухам Украины дайнаас үүдэн Төв Азид шинэ их тоглоом эхэлсэн гэвэл өрөөсгөл бөгөөд зайлшгүй үүсэх их тоглоомыг хурдасгасан хүчин зүйл болсон хэмээн дүгнэвэл бодит байдалд дөхнө.

Нөгөө талд их гүрнүүдийн өрсөлдөөний талбар болох нь Казахстаны ашиг сонирхол биш. Олон улсын харилцааны системийн шилжилтийн нарийн төвөгтэй үйл явцыг мэдэрч, оновчтой шийдвэр гаргах замаар өөрийн байр суурийг бэхжүүлж, шинээр тогтох дэлхийн дэг журамд бүс нутгийн бодлогод баттай нөлөөлдөг “дунд гүрэн” болж төлөвшихийг зорьж байгаа юм. Өөрөөр хэлбэл хөршүүдтэйгээ эрх тэгш харилцаж, харилцан ашигтай хэлцэл хийж чаддаг тоглогч болох зорилготой гэж ойлгож болно.

Түүх, газарзүй, геополитикийн хүчин зүйлсийн үүднээс авч үзвэл ОХУ нь Казахстаны гадаад бодлогод онцгой байр суурь эзэлдэг. Тухайлбал, Казахстаны 2020-2030 онд баримтлах гадаад бодлогын үзэл баримтлалд “*ОХУ-тай холбоотны харилцааг цаашид улам хөгжүүлнэ*” хэмээн тодорхой заасан (Ақорда, 2020). ОХУ, Казахстан хоёр ЕАЭЗХ, ХАБГБ, ТУХН, ШХАБ зэрэг олон талт механизмаас гадна хоёр талт харилцааны хүрээнд нягт хамтран ажилладаг түншүүд билээ. 2022 оны 1-р сард Казахстанд болсон бослогыг ОХУ-ын тэргүүлдэг ХАБГБ-ын шугамаар цэрэг оруулж дарсан үйл явдал хоёр улсын “холбоотны” харилцааг олон улсад нотлон харуулсан. Гэвч үүнээс хагас жил хүрэхгүй хугацааны дараа буюу 2022 оны 6-р сард Санкт-Петербургийн олон улсын эдийн засгийн форумын үеэр Казахстаны Ерөнхийлөгч К.К.Токаев ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинд хандан “*Казахстан Улс нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх олон улсын эрх зүйн зарчмыг баримталж, Луганск, Донецкын Бүгд найрамдах улсуудын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй*” (Rickleton, 2022) гэдгээ ил тод мэдэгдсэн. Уг үйл явдал олон нийтэд Казахстан Улс ОХУ-аас “зугуухан холдож” байна хэмээх сэтгэгдэл төрүүлж байсан нь үнэн боловч, прагматикаар дүгнэвэл Казахстан Улс өөрийн гэсэн бодлоготой, бие даасан, тусгаар улс гэдэг ойлголтыг олон улсад түгээх зорилго агуулж байсныг ойлгох ёстой.

“Холбоотны” хувьд Казахстан Украины асуудлаар НҮБ-д явагдсан санал хураалтуудад тогтмол “түдгэлзсэн” санал өгч ирсэн боловч нөгөө талд хөрш орондоо түрэмгийлэл үйлдсэн ОХУ-ыг өөрийн холбоотон, аюулгүй байдлын гол батлан даагч гэж хардаг итгэл нь эргэлзээтэй болж эхэлсэн. Иймээс батлан хамгаалах чадавхаа нэмэгдүүлэх, улс төр-дипломатын холбоогоо өргөжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулах болов. Улс төр, эдийн засгийн хувьд ОХУ, БНХАУ, ЕХ зэрэг их гүрнүүдийн тэнцвэрийг хангахыг оролдож байгаа бол батлан хамгаалах салбарт аль

нэг их гүрэнтэй бус, БНТУ-тай харилцаагаа өргөжүүлэхэд анхаарал хандуулж байна. Мөн C5 платформ, Түрэг Улсуудын Байгууллага зэрэг механизмуудаар дамжуулан ашиг сонирхлоо хамгаалахыг оролдож байна.

Хоёр. Украины дайн ба олон нийтийн санаа бодол

Гадаад бодлогын шийдвэр гаргалтад дотоод хүчин зүйлсийг тооцох шаардлагатай. Энэ тухай Америкийн судлаач Р.Путнам хоёр шатлалт тоглоомын онолдоо “*гадаад бодлогыг шийдвэр гаргалтад олон улсын нөхцөл байдлаас гадна олон нийтийн санаа бодол зэрэг дотоод орчны шахалт нөлөөлж байдаг*” хэмээн дурдсан (Putnam, 1988). Казахстан Улсын хүн ам 2024 оны байдлаар 20,03 сая байгаа бөгөөд үүнээс казах үндэстэн 14,2 сая буюу 71.0%, орос үндэстэн 2,9 сая буюу 14.9%-ийг бүрдүүлж байна (Үлттук статистика бюросы, 2024). Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Казахстан Улс “кандас”-ын бодлогын хүрээнд хилийн чанадаас казах гаралтай иргэдийг “түүхэн эх орон”-д нь татан авчрах ажлыг идэвхтэй хэрэгжүүлж байгаа хэдий ч орос гаралтай иргэд Казахстаны хоёр дахь голлох үндэстэн хэвээр байна.

Хүснэгт №1. Казахстан дахь голлох үндэстнүүд

	Ethnic groups	1991	1999	2009	2016	2019	2021
1	Kazakhs	43.1%	55.3%	63.1%	66.5%	67.9%	69.0%
2	Russians	37.3%	29.9%	23.7%	20.6%	19.3%	18.4%
3	Uzbeks	2.1%	2.5%	2.8%	3.1%	3.2%	3.3%
4	Ukrainians	5.3%	3.6%	2.1%	1.6%	1.5%	1.5%
5	Uighurs	1.1%	1.4%	1.4%	1.4%	1.3%	1.4%
6	Tatars	2.0%	1.7%	1.3%	1.1%	1.1%	1.1%
7	Germans	5.1%	2.4%	1.1%	1.0%	1.0%	1.0%

Эх сурвалж: Cabar Asia. <https://cabar.asia/en/kazakhstan-s-ethnic-policy-1991-2021-what-needs-to-change>

Москватай харилцах гадаад бодлогын шийдвэр гаргалтдаа Казахстаны эрх баригчид дотоодын хүн ам зүйн энэхүү өвөрмөц нөхцөл байдлыг анхаарч үздэг нь тодорхой. 1991 оноос эдүгээг хүртэл Казахстаны эрх баригчид казах хэл, шашин, соёлыг түгээхдээ орос болон бусад үндэстний соёлын онцлогийг хязгаарлахгүй байхад онцгой анхаарал хандуулж ирсэн. Улсын бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхийг хадгалахын тулд 130 гаруй үндэстний эв нэгдлийг хангах нь төрийн хар хайрцгийн бодлогын салшгүй хэсэг юм.

Украины дайны асуудлаарх Казахстаны гадаад бодлогын шийдвэр гаргалтад тооцох ёстой дотоод орчны хамгийн гол хүчин зүйлийн нэг нь олон нийтийн санаа бодол юм. Дан ганц орос гаралтай иргэдээс гадна түүхэн шалтгааны улмаас казах болон бусад үндэстнүүд ОХУ-ын талыг баримтлах магадлал өндөр байсан. Нөгөө талд өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд барууны улс орнууд хэвлэл мэдээлэл, боловсролын солилцооны хөтөлбөр, нийгэм рүү чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан хэрэгжүүлсэн зөөлөн хүчний бодлогын үр дүнд Казахстаны нийгэмд залуу иргэдийн дунд либерал үнэт зүйлсийг эрчимтэй түгээж чадсан.

Казахстаны ард иргэд Украины дайны асуудлаар ямар байр суурьтай байгааг DEMOSCOPE мониторингийн товчоо 2022 оноос хойш тогтмол тандан судалж байна.


График №1 Demoscope санал асуулгын үр дүн



Эх сурвалж: Demoscope. <https://demos.kz/category/saualnama/?lang=kz>

Түүвэр судалгаанд Казахстаны 18 муж, Астана, Алматы хотын иргэдээс бүрдсэн нийт 1,500 хүнийг хамруулсан. Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн дунд дайны асуудалд төвийг сахих байр суурь давамгайлж байна. Энэ нь Казахстаны төрийн албан ёсны бодлоготой ч нийцэж байгаа юм. Анх 2022 оны 3-р сарын 1-нд Ерөнхийлөгч К.К.Токаев талуудад асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэх ёстой хэмээн уриалж, шаардлагатай тохиолдолд зуулчлагчийн үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгаагаа илэрхийлснээс (Sputnik, 2022) хойш талуудыг хэлэлцээ хийхийг тууштай уриалсаар байна.

График №2 Demoscope санал асуулгын үр дүн



Эх сурвалж: Demoscope. <https://demos.kz/category/saualnama/?lang=kz>

Дайны ирээдүйн үр дагаврын тухайд Казахстаны иргэд “талууд зуучлагч улсын тусламжтай тохиролцоонд хүрнэ” гэх хувилбарт хамгийн их ач холбогдол өгч байна. Өрнийн орнуудын тусламжтай Украины тал дайнд ялалт байгуулах магадлал 2022, 2023 онуудад дунджаар 8%-ийн санал авч байсан боловч 2025 онд 4.70% болж огцом буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь Украины дайны асуудлаарх Вашингтоны шинэ засаг захиргааны баримтлах бодлого өөрчлөгдсөнтэй холбоотой байж магадгүй. Ямартай ч Казахстаны тал дайтагч талуудад зуучлал үзүүлэхэд бэлэн байгаа амбицаа илэрхийлсэн.

Харин ОХУ, Украиныг яг хэрхэн зөвшилцөлд хүрэх тухайд Казахстаны тал БНХАУ болон Бразил улсаас дэвшүүлсэн энхийн төлөвлөгөөг дэмжиж байгаагаа 2024 оны 9-р сард болсон ХБНГУ-ын Канцлер О.Шульцын айлчлал (Qazinform, 2024) болон, 10-р сард болсон Астана олон улсын тинк танк форумын үеэр (Qazinform, 2024) тус тус илэрхийлсэн.

График №3 Demoscope санал асуулгын үр дүн



Эх сурвалж: Demoscope. <https://demos.kz/category/saualnama/?lang=kz>

Санал асуулгын гол асуултуудын нэг болох “ОХУ Казахстан руу довтлох боломжтой юу?” гэсэн асуултад иргэдийн 58% нь “боломжгүй” гэж хариулсан. Хэдийгээр 50%-иас их үзүүлэлт хэдий ч 2022 онтой харьцуулахад Казахстаны иргэд Москвад итгэх итгэл 15 орчим хувиар буурсан гэж дүгнэж болохоор харагдаж байна.

Ард иргэдийн санаа бодлыг ерөнхийлөн дүгнэхэд Казахстан Улсын төвийг сахих бодлогыг дэмжиж байгаа нь тодорхой харагдаж байна. Мөн санал асуулгад оролцогчдын дийлэнх хувь ОХУ Казахстан руу довтлох магадлал бага хэмээн үзэж байгаа ч, тогтмол буурч

буй зүй тогтолд Өрнийн орнуудын хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж буй зөөлөн хүчний бодлого зохих нөлөө үзүүлж байгааг үгүйсгэх аргагүй. Нөгөө талд Казахстаны Засгийн газрын хувьд олон нийтийн санаа бодолтой уялдуулан Москвагаас хэт хамааралтай байдлаа бууруулах, бие даасан байдлаа бэхжүүлэхэд шаардлагатай стратегийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх таатай хөрс суурь бүрдэж байна гэх дүр зураг харагдаж байна.

Олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд мэдээлэл авч буй эх сурвалж гол нөлөө үзүүлнэ гэж үзвэл дээрх санал асуулгад оролцогчдын талаас илүү хувь нь нийгмийн сүлжээний платформуудаар дамжуулан мэдээлэл авсан гэдгийг дурдах ёстой. АНУ-ын зөөлөн хүчний бодлого Төв Азийн орнуудад боловсролын солилцооны хөтөлбөр болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин тархдаг. 2022 оноос хойш өрнөсөн мэдээллийн дайнд Казахстаны ард иргэд өртөөгүй гэвэл өрөөсгөл болно. Вашингтоны зүгээс USAID агентлагийн Төв Ази дахь төсөл хөтөлбөрүүдийг хязгаарлах болсон мөн, Казахстанд “гадаадын агентуудын тухай” хуулийг Мажлис хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулан тус улсад мэдээллийн урсгалын чөлөөт байдал хумигдах эрсдэлтэй нөхцөл үүссэн хэмээн шүүмжлэлд өртөх болсон.

Энэ тухай Казахстаны Төрийн зөвлөх Ерлан Карин “*Зарим гадаадын санхүүжилттэй ТББ, хувь хүмүүст Казахстан Улсад болж буй үйл явдлыг үнэн бодитоор илэрхийлэх сонирхол байдаггүй. Энэ нь тэдний аливаа асуудлаас ашиг хонжоо хайдагтай нягт холбоотой. Тэдэнд асуудлыг шийдэх ямар ч хүсэл байдаггүй. Учир нь асуудал шийдэгдэхгүй байх нь тэдэнд сэтгэл санааны болоод санхүүгийн хувьд ашигтай байдаг. Казахстан Улсад болж буй шинэчлэл, эерэг өөрчлөлтийг үгүйсгэж, ардчилал, эрх чөлөө байдаггүй авторитар улс гэж харагдуулснаар тэдгээр байгууллага, хүмүүсийн санхүүжилт хэвийн үргэлжлэх нөхцөл бүрддэг. Үүнийг бизнес гэхэд хилсдэхгүй*” хэмээн эрс шулуун байр сууриа илэрхийлэв (Qazinform, 2025). Түүний мэдэгдлийг аль ч өнцгөөс тайлбарлаж болох боловч Казахстаны эрх баригчид ард түмнээ өдөөн турхиралт, мэдээллийн дайнаас хамгаалах, дотоод эв нэгдлийг хадгалахад анхаарал хандуулж байгаа нь тодорхой байна.


Гурав. Эдийн засгийн нөхцөл байдал ба цаашдын төлөв

Дайны нөхцөл байдлаас шалтгаалж Казахстаны Каспийн хоолойн консорциум (CPC)-аар дамждаг байгалийн хийн экспорт хумигдах, компаниуд ОХУ-руу хоёрдмол зориулалттай бараа (*Dual use goods*) экспортолноос болж Барууны орнуудын хоригт өртөх, дотоодын зах зээлээ хамгаалах үүднээс Москвагаар “худалдааны дайн хийх” зэрэг таагүй үйл явдлуудтай нүүр тулсан. Гэвч дээрх сорилтуудтай зэрэгцэн газрын ховор элемент болон бусад минералын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж олон улсаас хөрөнгө оруулалт татах, БНХАУ, ЕХ-ны ашиг сонирхлыг нэгтгэн зангидаж дунд коридорын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бүх нийтийн санал асуулга явуулж цөмийн цахилгаан станц байгуулах замаар эрчим хүчний хамаарлаас гарах болон бусад стратегийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлэх түүхэн шийдвэрүүдийг гаргаад байна.

2024 онд Казахстаны гадаад худалдааны эргэлт 141.4 тэрбум ам.долларт хүрсэн ба үүнээс нийт экспорт 81.6 тэрбум ам.доллар, нийт импорт 59.7 тэрбум ам.доллар болж, худалдааны тэнцэл 21.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан (Үлттук статистика бюросы, 2024). Бээжин худалдааны хувьд Казахстан төдийгүй Төв Азийн бүс нутгийн орнуудын хамгийн чухал түнш оронд тооцогдож байна. 2024 онд БНХАУ-ын Төв Азитай хийсэн худалдааны эргэлт 94.82 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний тал хувь буюу 43.82 тэрбум ам.долларыг Казахстантай хийсэн худалдаа бүрдүүлсэн (Astanatimes, 2025). Гэтэл ОХУ-ын Төв Азийн бүс нутагтай хийсэн


худалдааны эргэлт 44 тэрбум ам.доллар байгаа нь БНХАУ-тай харьцуулахад хоёр дахин бага үзүүлэлт юм.

График №4 Казахстаны экспортын түншүүд



Эх сурвалж: <https://stat.gov.kz/industries/economy/foreign-market/publications/281737/>

График №5 Казахстаны импортын түншүүд



Эх сурвалж: <https://stat.gov.kz/industries/economy/foreign-market/publications/281737/>

Казахстаны Үндэсний статистикийн товчооны мэдээллээс үзэхэд ОХУ тус улсын экспортын гурав дахь гол түнш, импортын хамгийн чухал түнш байна. 2024 оны сүүлээр дотоодын зах зээлээ хамгаалах үүднээс Казахстаны Засгийн газар Москвагаас импортолж буй улаан буудайн бүтээгдэхүүнүүдэд хязгаарлалт тогтоосны хариуд Оросын тал Казахстаны бүтээгдэхүүнүүдэд хязгаарлалт тогтоож “худалдааны дайн” өрнүүлсэн (The Moscow Times, 2024). ЕАЭЗХ-ны дотоод уур амьсгал, бодит байдлыг дээрх үйл явдлаас харж болох юм.

Гадаадаас шууд хөрөнгө оруулалт татах ажилд Казахстан арвин туршлагатай. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд Казахстан гадаадаас 431 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан нь Төв Азийн бүс нутагт орж ирсэн нийт хөрөнгө оруулалтын 70 хувийг эзэлж байна. 2024 онд Төв Ази руу 24.8 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орсны 63.3 хувь буюу 15.7 тэрбум нь Казахстаны эдийн засагт орсон (The Times of Central Asia, 2024). Казахстаны Засгийн газар 2024 онд 2029 он хүртэлх “Хөрөнгө оруулалтын бодлогын үзэл баримтлал”-аа шинэчилж, ирэх 5 жилд 150 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.


Хөрөнгө оруулагчдын анхаарлыг газрын ховор элемент, дэд бүтэц, тээвэр, эрчим хүчний салбарын төсөл хөтөлбөрүүдэд татахыг оролдож байна. Ерөнхийлөгч К.К.Токаев ээлжит илгээлтдээ “шинэ зууны газрын тос” болоод буй газрын ховор элементийн орд газруудыг илрүүлэх, нөөцийг шинэчлэн тогтоох ажил Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байхыг тодотгосон (Ақорда, 2023). Тэрээр 2026 он гэхэд дор хаяж 2.2 сая километр.кв газар нутагт геологийн хайгуулын ажил хийх шаардлагатайг онцолсон.

Худалдаа, хөрөнгө оруулалтын салбарыг товчхон дүгнэвэл Казахстан Улс бүс нутагтаа тэргүүлж байна. Хэдийгээр Бээжинд байр сууриа алдсан боловч ОХУ худалдааны чухал түншийн нэг хэвээр байна. Энэ онд Астана хотод болох Төв Ази, Хятад дээд хэмжээний уулзалтаар худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлуудыг хөндөх төлөвтэй байна. АНУ-ын хувьд 2024 онд Казахстантай 3.4 тэрбум ам.долларын худалдаа хийсэн. Худалдааны хэмжээ харьцангуй бага байгаа ч Казахстаны гол байгалийн хийн орд газруудад Шеврон, Ексон Мобиль зэрэг компаниуд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Д.Трампын засаг захиргаа Казахстанд 27%-ийн тариф оногдуулсан хэдий ч энэхүү хязгаарлалт нь Казахстанас АНУ руу гарч буй бараа бүтээгдэхүүний 92%-д үйлчлэхгүй тухай Казахстаны Худалдааны яам мэдэгдсэн (The Times of Central Asia, 2025). Жил бүр өссөн үзүүлэлттэй гарч буй тоон мэдээллээс үзэхэд одоогийн байдлаар Украины дайн Казахстаны гадаад худалдаанд ямар нэгэн шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

Дөрөв. СРС хоолой ба экспортын нэмэлт маршрутын эрэл

Украины дайны Казахстаны эдийн засагт үзүүлж буй хамгийн эмзэг цэг бол яах аргагүй Каспийн хий дамжуулах хоолойн асуудал юм. 2024 онд Казахстан ЕХ-ны газрын тосны хэрэглээний 13%-ийг дангаараа хангасан. ОХУ-аар дамждаг Каспийн хоолойн консорциум (СРС) Казахстаны байгалийн хий, газрын тосыг Европ руу тээвэрлэх гол дэд бүтцэд тооцогддог.

График №6. Казахстаны газрын тосны экспорт




Эх сурвалж: [Sputnik.kz](https://sputnik.kz)

Газрын тосны салбар Казахстаны экспортын орлогын 40 орчим хувь, төсвийн нийт орлогын 27.2 хувийг дангаараа бүрдүүлдэг. Тус улс 2024 онд 87 сая тонн газрын тос олборлосноос 68.6 сая тонн буюу 78.9 хувийг экспортод гаргасан. Төсвийн орлогын гуравны нэгийг бүрдүүлдэг газрын тосны экспортын 80 хувь нь ОХУ-ын нутгаар дамждаг СРС-аар тээвэрлэгддэг болохыг дээрх графикаас харж болно.

Украины дайн эхэлснээр газрын тосны экспортыг тогтвортой байлгах нь Казахстаны эрх баригчдын хувьд тулгамдсан асуудал болоод байна. Нэг талаас Москва Астанад улс төрийн шахалт үзүүлэхдээ CPC-г хөшүүрэг болгодог бол нөгөө талд Украины Москвагийн эрчим хүчний дэд бүтцүүдэд өгч буй цохилтуудад CPC хоолой өртсөөр байна. Тус хоолой нь Казахстаны Атырау мужийн нутагт байрлах Тенгиз газрын тосны орд газраас эхэлж, ОХУ-ын Краснодар мужийн Новороссийск боомт хүртэл 1.510 километр үргэлжилдэг.

Одоогийн байдлаар CPC-ын 24 хувийг ОХУ-ын төрийн өмчит Транснефть, 19 хувийг Казахстаны төрийн өмчит Казмунайгаз, 15 хувийг АНУ-ын Шеврон компаниуд эзэмшиж байна.

График №7. CPC хувьцаа эзэмшигчид



Эх сурвалж: Caspian Pipeline Consortium [CPC](#)

2025 оноос эхлэн Украин CPC хоолойд хэд хэдэн удаа халдлага үйлдээд байна. Тухайлбал, 2025 оны 2-р сарын 17-нд Кропоткинская дахь станцад халдлага үйлдсэн. Мөн 3-р сар 8-р сард тус бүр халдлага үйлдсэн боловч амжилтгүй болсон. Харин 11-р сарын 28-нд Новороссийск боомтод байрлах терминал руу довтолж, их хэмжээний хохирол учруулсан тул Казахстаны Гадаад хэргийн яам “... (Украин) Олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан иргэний зориулалттай байгууламжид гурав дахь удаагаа халдан довтоллоо. Үүнийг Казахстан болон Украин хоёр улсын харилцаанд сөргөөр нөлөөлөх үйл явдал боллоо хэмээн дүгнэж байна. Украины тал цаашид дахин ийм явдал гарахаас сэргийлж, бодит үйлдэл хийнэ хэмээн найдаж байна” хэмээн эсэргүүцэл илэрхийлэв (Azattyq, 2025). Харин Украины тал хариу мэдэгдэлдээ “... Украины хийж буй довтолгоонууд нь Казахстан, эсвэл өөр гуравдагч орны эсрэг чиглээгүй. НҮБ-ын дүрмийн 51-р зүйлд заасан өөрийгөө хамгаалах эрхийн хүрээнд, Оросын бүрэн хэмжээний түрэмгийллийг зогсоохоор тэмцэж байна. Мөн Казахстаны тал өмнө нь ОХУ-ын Украины иргэний байгууламжуудад хийсэн цохилтуудыг буруушаасан мэдэгдэл гаргаагүйд харамсаж байна” гэв (Rubryka, 2025).

Казахстаны Засгийн газрын зүгээс халдлагатай холбоотойгоор төсвийн алдагдал үүсэх эрсдэл бага хэмээн мэдэгдэж байгаа ч судлаачдын хувьд засварын ажилд хугацаа их орсон тохиолдолд алдагдал 1.5 тэрбум ам.долларт хүрэх эрсдэлтэй хэмээн тооцож байна. Мөн цаашид ч гэсэн Украины халдлага үргэлжлэх магадлалтай гэж үзэж байгаа тул зарим судлаачид

өөрсдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд зэвсэгт хүчнийг ашиглах ёстой гэх санаа дэвшүүлэх болов. Тухайлбал, судлаач Куат Домбай Казахстан СРС-г цэргийн хүчээр хамгаалах эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд, хэрэв ингэсэн тохиолдолд Украины довтолгооноос хамгаалах баталгаа болох боломжтой хэмээн үзэв (Atameken Business, 2025). Хэдийгээр төр зэвсэгт хүчнийг ашиглах магадлал бага, судлаачдын түвшинд яригдаж байгаа асуудал ч гэлээ энэ нь цаашид Украиныг СРС-д довтолхгүй байхад дипломат шахалт үзүүлэх нэг хөшүүрэг болж байгаа юм.

Казахстаны тал газрын тосны экспортын нөөц маршрут бий болгох чиглэлээр 30 гаруй жил ажилласан боловч тодорхой шийдэл олоогүй байна. Одоогийн байдлаар Актау боомтод танкераар Баку-Тбилис-Чейхан (BTC) хоолой руу, Атырау-Самара хоолойгоор Оросын Дружба хоолой руу, Атасу-Алашанькоу хоолойгоор Хятад руу зөөж байна. Гэвч эдгээрийн аль нь ч СРС-г орлож чаддаггүй. Дээр дурдсан сүлжээнүүдээр нийт экспортын ердөө 20 хувь буюу 13.7 сая тонн газрын тос тээвэрлэгдэж байна.

Зураг №1. Казахстаны газрын тосны экспортын маршрут



Эх сурвалж: hellenicshippingnews.com

Астана BTC хоолойгоор тээвэрлэх хэмжээг нэмэх хүсэлтэй ч боловч дэд бүтцийн саад бэрхшээлийн улмаас тээвэрлэлтийн зардал нэмэгдэж, улмаар энэ хувилбар төдийлөн дэмжигдэхгүй байна. Хэдийгээр BTC хоолойгоор 1 тонн газрын тосыг 25 ам.доллаароор тээвэрлэдэг буюу СРС хоолойноос даруй 13 ам.доллаароор хямд байгаа ч Атырау-Актауыг холбосон хоолой тавигдаагүй учир улс дотор тээврийн зардал үнэтэй болдог. Мөн Актауын боомтод хамаарах Каспийн тэнгисийн зүүн эргийн ус гүехэн тул том хэмжээтэй танкер оруулах боломжгүй байдал нь тээвэрлэлтийн улам үнэтэй болгож байна.

Зураг №2. Казахстаны газрын тосны хоолой



Эх сурвалж: Kazakh-China Pipeline LLP www.kcp.kz

Түүнчлэн, Хятад ба Казахстаныг холбосон Атасу-Алашанькоу хоолойн хүчин чадал 20 сая тонн боловч Казахстаны тал 2024 онд ердөө 1.2 сая тонн газрын тос экспортолсон. Үүний шалтгаан нь нэгдүгээрт, Казахстаны тал Европын зах зээл рүү бүтээгдэхүүнээ үнэтэй зарах хүсэлтэй байгаа явдал юм. Тухайлбал, Хятадын тал газрын тосны нийлүүлэлтийн сүлжээгээ төрөлжүүлж чадсаны үр дүнд Brent төрлийн газрын тосыг зах зээлийн үнээс 5-10 ам.доллар хямдруулж авдаг тул Казахстан төдийлөн сонирхдоггүй.

Хоёрдугаарт, Оросын тал газрын тосоо Хятад руу Атасу-Алашанькоу хоолойгоор транзит тээвэрлэдэг. Үүний цаана Астана Москвад бүтээгдэхүүнээ транзит тээвэрлэх боломж олгож, хариуд нь СПС-н үйл ажиллагаанд ямар нэг саад учруулахгүй байх улс төрийн тохироонд хүрсэн байх магадлалтай.

Гэвч СПС халдлагад өртөх болсноор Астана ирээдүйд Хятад руу хийх экспортоо нэмэгдүүлэх бодлого баримталж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна. Тухайлбал, СПС-ын халдлагын дараа Казахстан анх удаа Кашаганы ордоос Атасу-Алашанькоу хоолойгоор Хятад руу 50.000 тонн газрын тос экспортлохоор болоод байна (Reuters, 2025). Кашаганы орд нь Европын зах зээлийг хангадаг гол ордуудын нэг бөгөөд ийнхүү Хятад руу экспортын туршилт хийж байгаа нь Казахстаны эрх баригчдын хувьд хэдийгээр алдагдалтай ч гэсэн Хятад экспортын найдвартай нөөц сүлжээ болох боломжтой гэж харж байгаатай холбоотой байж болох юм.

Хэрэв Украины тал үргэлжлүүлэн СПС хоолойд халдлага үйлдэх бол Казахстан цэргийн хүчээр хамгаалах оролдлого хийхгүй юм гэхэд төсвийн алдагдлыг бага байлгахын тулд Хятад руу нийлүүлэлтээ нэмэгдүүлэхээс өөр сонголтгүй болно. Энэ нь АНУ, ЕХ тэргүүтэй барууны орнуудын хувьд тийм ч таатай үйлдэл болохгүй.

Дүгнэлт

Казахстан Улс бүс нутгийн дунд гүрний хувьд геополитикийн ээдрээт цаг үед өөрийн ашиг сонирхлыг хангах, Евразийн бүс нутгийн тогтвортой байдлыг хадгалахад зохих хувь нэмрийг оруулж чадаж байна. 2022 оноос хойш үргэлжилсэн үйл явдлууд Казахстаны эрх баригчдад улс орны гадаад, дотоод орчны бодит нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийх боломж олгосон онцлогтой жилүүд байв.

Гадаад орчноос ирэх шахалтуудыг тэнцвэржүүлж, олон чиглэлт гадаад бодлого хэрэгжүүлэхэд дан ганц Казахстаны дотоод чадавхаас гадна бүс нутгийн орнуудын “органикаар” ойртон нягтарч буй байдал дэмжлэг үзүүлж байгааг санах хэрэгтэй. Украины дайн эхэлснээс хойш зөвхөн төрийн тэргүүнүүдийн түвшинд гэхэд C5+1 форматаар АНУ, БНХАУ, ОХУ, ЕХ, Персийн булангийн хамтын ажиллагааны зөвлөл, ХБНГУ зэрэг тоглогчидтой дээд хэмжээний уулзалт зохион байгуулаад байна. Төв Азийн орнуудын хувьд шинэ их тоглоомын талбар болохоос илүүтэй дэлхийн дэг журамд өөрчлөлт орж буй энэ цаг үед гарч ирсэн боломжийг ашиглаж олон чиглэлт гадаад бодлогоороо дамжуулж өөрсдийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх ажлыг эрчимтэй хийж байна.

Өрнийн судлаачид Казахстан Москвагаас аажмаар холдож байна хэмээн дүгнэх болсон ч Казахстаны тал албан ёсоор ОХУ-тай харилцах харилцаа нь тус улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэвээр гэдгийг тогтмол мэдэгдсээр байгаа. Өөрөөр хэлбэл, их гүрнүүдийн дунд оршдог жижиг, дунд улсууд аль нэг талд орохгүй, тэнцвэртэй бодлого баримталдаг “бичигдээгүй хуулийг” Казахстан ягштал мөрдөж байна гэж хэлж болно.

БНХАУ-ын хувьд Казахстаныг “*мөнхийн иж бүрэн стратегийн түнш*” хэмээн тодорхойлдог. Одоогийн байдлаар ОХУ-ын нөлөөг тэнцвэржүүлэхэд бодит хөшүүрэг болж чадах цорын ганц тоглогч мөн. Гэвч аажимдаа улс төрд нь нөлөөгөө тогтоож, эдийн засгийг нь өөрөөсөө бүрэн хамааралтай болгох замаар Төв Азийг өөрийн нөлөөнд бүрэн авах бодлоготой. Казахстаны ашиг сонирхол Оросын нөлөөг Хятадаар солих биш тул ирээдүйд учирч болох Хятадын аюулыг хязгаарлахад ОХУ-ын нөмөр зайлшгүй хэрэгтэй.

Үүнээс гадна ЕХ болон АНУ-ын ашиг сонирхлыг бий болгох замаар Орос, Хятадын нөлөөг тэнцвэржүүлэх зорилт тавьж байна. Нэн ялангуяа газрын ховор элементийн хайгуул, олборлолтын салбарт баруунтай хамтран ажиллах сонирхол их байгаа. АНУ, ЕХ ч гэсэн Казахстантай хамтран ажиллах, Орос, Хятадын дундын бүсэд нөлөөгөө тогтоохыг оролдож байна.

Вашингтонд төвтэй Каспийн бодлогын төвийн хийсэн судалгаанд Төв Азийн бүс нутгийг Кавказаас салгаж болохгүй хэмээн дурдсан (Rudenshiold, 2025). Газарзүйн байрлал, транзит тээврийн нөхцөл байдлын үүднээс энэ нь прагматик дүгнэлт юм.

Украины дайны Казахстанд өгсөн дараагийн чухал сургамж нь гадаад таатай орчин бүрдүүлэхээс гадна дотооддоо аж үйлдвэр хөгжүүлэхэд анхаарах байв. Засгийн газрын зүгээс 2029 он хүртэл баримтлах дэд бүтэц, аж үйлдвэрийн хөгжлийн төлөвлөгөөг тус тус баталсан. Жил бүр гадаад худалдааны тэнцэл ашигтай гардаг улсын хувьд ашгаа стратегийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулахад зориулж байна. Атомын цахилгаан станц байгуулах шийдвэр гаргаснаас хойш бодит ажил хэрэг болох үйл явц эрчимтэй урагшилж байна.

“Автократ” тодотголтой Казахстаны улс төр, нийгэм, эдийн засагт шүүмжлэлтэй хандаж болох асуудал олон байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ зарчмын хувьд аливаа улсын төрийн бодлого нь зөв чиглэлд явж байгаа эсэхэд зөвхөн тухайн улсын ард түмэн нь үнэлэлт дүгнэлт өгөх нь зүйд нийцнэ. Түүвэр судалгаагаар Казахстанчуудын 61.4 хувь нь Казахстан Улс зөв чиглэлд явж байна гэж үзсэн, 75 орчим хувь нь К.К.Токаевыг дэмжиж байгаа гэсэн үр дүн гарсан (Demos.kz., 2023).

Украины дайн Казахстаны эдийн засаг, гадаад бодлогод цаг зуурын хүндрэл бэрхшээлүүд үүсгэж байгаа ч, том зургаар харвал бүс нутгийн орнуудтайгаа ойртон нягтрах, их гүрнүүдтэй бүгдтэй нь эрх тэгш харилцаж, харилцан ашигтай хамтран ажиллах том боломж

олгож байна. Цаашид Казахстан Улс одоо байгаа тэнцвэрийг хадгалж гадаад бодлогоо хэрэгжүүлэх ба, гадаадын технологи, капиталын тусламжтай эдийн засгаа хөгжүүлэх бодлогоо үргэлжлүүлнэ.

Чухам хэзээ нэгэн цагт ОХУ, БНХАУ-ын харилцаанд эргэлт гарсан тохиолдолд Казахстаны гадаад орчинд ихээхэн таагүй нөхцөл үүсэх юм. Ямартай ч Казахстан Улс одоогийн байдлаар олдсон боломжийг алдахгүй ашиглаж, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх, хүч чадавхаа нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй хийж байна.

НОМ ЗҮЙ:

Хууль, эрх зүйн баримт бичгүүд:

Казах хэлээр:

1. Акорда. (2020, Мар 9) *Қазақстан Республикасы сыртқы саясатының 2020–2030 жылдарға арналған тұжырымдамасы туралы*, Қазақстан Республикасы Президентінің 2020 жылғы 6 наурыздағы №280 Жарлығы, https://www.akorda.kz/kz/legal_acts/decrees/kazakstan-respublikasy-syrtky-sayasatynyn-2020-2030-zhyldarga-arnalghan-tuzhyrymdamasy-turaly

Ном зохиол, нэг сэдэвт бүтээл:

Англи хэлээр:

1. Kaplan, M. A. (1957). *System and Process in International Politics*. New York: John Wiley & Sons.
2. Putnam, R. D. (1988). *Diplomacy and domestic politics: The logic of two-level games*. *International Organization*, 42(3), 427–460.

Цахим эх сурвалж:

Англи хэлээр:

1. The Kremlin. (2022, Feb 24). *Address by the President of the Russian Federation*, <http://en.kremlin.ru/events/president/news/67843>
2. Rickleton, C. (2022, Jun 24). *Ukraine war strains ties between Kazakhstan and Russia*. *The Moscow Times*. <https://www.themoscowtimes.com/2022/06/24/ukraine-war-strains-ties-between-kazakhstan-and-russia-a78100>
3. Qazinform. (2024, Sep 16). *Tokayev Makes Remarks on Settlement to Ukrainian Situation* Kazinform, <https://qazinform.com/news/tokayev-makes-remarks-on-settlement-to-ukrainian-situation-2742a2>
4. Qazinform. (2024, Oct 17). *Head of State on Russian-Ukrainian Conflict: Striving for Peace Through Negotiations is Strategic Prudence*. Kazinform. <https://qazinform.com/news/head-of-state-on-russian-ukrainian-conflict-striving-for-peace-through-negotiations-is-strategic-prudence-3ae816>
5. Astanatimes. (2025). *Kazakhstan Ranks First Among China's Central Asian Trade Partners in 2024*. <https://astanatimes.com/2025/01/kazakhstan-ranks-first-among-chinas-central-asian-trade-partners-in-2024/>
6. The Moscow Times. (2024, Oct 18). *Russia Restricts Fruit, Vegetable Imports from Kazakhstan*. <https://www.themoscowtimes.com/2024/10/18/russia-restricts-fruit-vegetable-imports-from-kazakhstan-a86736>
7. Times Cental Asia. (2024, Dec 31). *Central Asia Attracted \$24.8 Billion in Investments in 2024*. <https://timesca.com/central-asia-attracted-24-8-billion-in-investments-in-2024/>

8. Times Central Asia. (2025, Apr 14). *Trump's Trade War Against China: Opportunities and Risks for Central Asia*. <https://timesca.com/trumps-trade-war-against-china-opportunities-and-risks-for-central-asia/>
9. Rubryka. (2025, Dec 1). *MFA: No actions of Ukraine are directed against Kazakhstan or other third parties*. <https://rubryka.com/en/2025/12/01/mzs-zhodni-diyi-ukrayiny-ne-spryamovani-proty-kazahstanu-chy-inshyh-treth-storin/>
10. Reuters. (2025, Dec 8). *Kazakhstan to supply some Kashagan oil to China directly due to CPC damage, sources say*. <https://www.reuters.com/business/energy/kazakhstan-supply-some-kashagan-oil-china-directly-due-cpc-damage-sources-say-2025-12-08/>
11. Rudenshiold, E. (2025, Jan 15). *A New U.S. Strategy for Central Asia and the Caucasus*. Caspian Policy Center, https://api.caspianpolicy.org/media/ckeditor_media/2025/01/15/eric-us-strategy-for-central-asia-and-caucasus_compressed.pdf
12. Demos.kz. (2023, May 17). *What People in Kazakhstan Think about the War in Ukraine*. <https://demos.kz/what-people-in-kazakhstan-think-about-the-war-in-ukraine-3/?lang=en>

Қазақ халқы:

1. Ұлттық статистика бюросы. (2024). Қазақстан Республикасының Стратегиялық жоспарлау және реформалар агенттігі Ұлттық статистика бюросы. *Демографиялық көрсеткіштер*. <https://stat.gov.kz/industries/social-statistics/demography/publications/157719/>
2. Sputnik Kazakhstan. (2022). *Тоқаев Ресей мен Украинаны келісімге келуге үндеді*. <https://sputnik.kz/20220301/toqaeve-resey-ukraina-kelisim-23191177.html>
3. Qazinform. (2025, Mar 25). *Көпшілік үшін бұл бизнеске айналды: Ерлан Карин шетелдік грант алушылар туралы*. Kazinform. <http://kaz.inform.kz/news/kopshlg-ushn-bul-bizneske-aynaldi-erlan-karin-sheteldk-grant-alushilar-turali-f89442/>
4. Ұлттық статистика бюросы. (2024). *Қазақстан Республикасы Стратегиялық жоспарлау және реформалар агенттігі Ұлттық статистика бюросы. Қазақстан Республикасының сырт Гагаагийн Алтанхишиг*, қы сауда айналымы (2024 жылғы қаңтар – желтоқсан)*. <https://stat.gov.kz/industries/economy/foreign-market/publications/281737/>
5. Ақорда. (2023). *Мемлекет басшысы Қасым-Жомарт Тоқаевтың “Әділетті Қазақстанның экономикалық бағыты” атты Қазақстан халқына Жолдауы*. <https://www.akorda.kz/kz/memleket-basshysy-kasym-zhomart-tokaevtyyn-adiletti-kazakstannyn-ekonomikalyk-bagdary-atty-kazakstan-halkyna-zholdauy-18333>
6. Azattyq. (2025, Nov 30) *Қазақстан СІМ Новоросийскідегі КТК инфрақұрылымына шабуылға байланысты Украинаға наразылық білдірді*. <https://www.azattyq.org/a/qazaqstan-sim-novorossiiskidegi-ktk-infraquyrylymyyna-shabuylyna-bailanysty-ukrainaga-narazylyq-bildirdi/33609065.html>
7. Atameken Business. (2025, Dec 6). *Қазақ әскерін ресейдегі каспий құбырын қорғауға жіберу керек – саясаттанушы | әлем тынысы* <https://www.youtube.com/watch?v=1CPHRnGWvG8>